



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2013 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 283

Мандалговь


Хөрөнгө бэлтгэж бүртгэх тухай

“Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.4 дэх заалтуудыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Орон нутгийн өмчийн албанд өөрийн хөрөнгөнөөс 2'918'500 /хоёр сая есөн зуун арван найман мянга таван зуу/ төгрөгөөр хавсралтан дахь 6 нэр төрлийн эд хөрөнгө худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Худалдан авсан эд хөрөнгийг байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж авахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/-д даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн албаны дарга /П.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.БУДЖАВ



Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 10 сарын
30 өдрийн 115-р тогтоолын хавсралт



Худалдан авах эд хөрөнгө

Д /д	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1.	Бичгийн шкаф	ш	1	339000	339000
2.	Принтер HPij-M1132-A10	ш	1	299900	299900
3.	Процессор Acer-LT-E1-471-23	ш	1	849900	849900
4.	Notebook Acer-DT-VM2611-32	ш	1	799900	799900
5.	Дэлгэц Acer-LED-G196	ш	1	179900	179900
6.	Камер Sony-DSR-CX22 silver	ш	1	449900	449900
Дүн			6		2918500